

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М. Батсуурь

Утас: 70453317

Цахим хаяг: batsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М. Бат-Амгалан

Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Ариун төгс оршихуй Аудит

ХХК-ийн аудитор: В. Сэлэнгэ

Утас: 9411-1882

Цахим хаяг: ariuntugsorshihuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ТАРИАЛАН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Ж.НАРАНТУЯА ТАНАА

2023.02.24 № УВА-2023/164/НА-СПА-ТЦЗ
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200138

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	142,631,296.25	224,588,006.63
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,265,972.50	118,443,998.43
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	28,265,972.50	118,443,998.43
3121	Төгрөг	28,265,972.50	118,443,998.43
31211	Төрийн сангийн харилцах	26,976,446.00	52,616,171.93
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	1,289,526.50	65,827,826.50
33	АВЛАГА	64,538,300.00	152,140.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	64,538,300.00	00.00
335	Бусад авлага	00.00	152,140.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	152,140.00
35	БАРАА МАТЕРИАЛ	49,827,023.75	105,991,868.20
351	Түүхий эд материал	13,775,953.75	54,100,249.90
35130	Эм боох материал	13,775,953.75	54,100,249.90
354	Хангамжийн материал	36,051,070.00	51,891,618.30
35410	Бичиг хэргийн материал	309,000.00	574,600.00
35420	Аж ахуйн материал	26,584,236.36	46,854,746.16
35440	Түлш, шатах тослох материал	3,607,850.00	00.00
35460	Хүнсний материал	2,682,483.64	1,594,772.14
35470	Бусад хангамжийн материал	2,867,500.00	2,867,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	628,195,747.67	591,104,482.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	628,195,747.67	591,104,482.20
392	Биет хөрөнгө	616,907,747.67	579,816,482.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	482,662,092.00	482,662,092.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-41,522,452.08	-57,139,690.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	144,900,000.00	144,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,861,041.75	-88,373,541.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	182,957,081.22	188,317,762.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,772,540.12	-126,071,706.65
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,650,110.50	41,220,110.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,560,501.98	-6,475,943.24
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,388,000.00	3,388,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,032,800.12	-2,710,400.16
39217	Ном	99,800.00	99,800.00
393	Биет бус хөрөнгө	11,288,000.00	11,288,000.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,288,000.00	11,288,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	770,827,043.92	815,692,488.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,577,119.00

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	6,577,119.00
413	Өглөг	00.00	6,577,119.00
4136	Бусад өглөг	00.00	6,577,119.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	6,577,119.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	770,827,043.92	809,115,369.83
51	Засгийн газрын хувь оролцоо	770,827,043.92	809,115,369.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	647,540,467.05	647,540,467.05
51101	Өмч: - төрийн	647,540,467.05	647,540,467.05
512	Хуримтлагдсан үр дүн	52,527,726.71	90,816,052.62
51210	Өмнөх үеийн үр дүн	52,527,726.71	52,527,726.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	38,288,325.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,758,850.16	70,758,850.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	770,827,043.92	815,692,488.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	826,867,668.46	840,981,645.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,756,588.46	43,525,848.90
120	Нийтлэг татварын бус орлого	127,756,588.46	43,525,848.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	127,756,588.46	43,525,848.90
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	127,756,588.46	43,525,848.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	230,939,580.00	797,455,796.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	468,171,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,353,100.00	65,827,826.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	92,353,100.00	65,827,826.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,810,200.00	44,810,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,810,200.00	44,810,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	95,776,280.00	686,817,770.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	95,776,280.00	686,817,770.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	655,944,769.14	802,693,319.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	655,944,769.14	802,693,319.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,110,130.64	693,355,646.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,923,161.00	386,693,999.64
210101	Үндсэн цалин	309,589,161.00	292,330,246.96
210102	Нэмэгдэл	12,583,217.00	71,490,058.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,820,000.00	5,326,000.00
210104	Урамшуулал	28,890,783.00	16,707,694.30
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	840,000.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,368,695.00	49,703,479.93
210201	Тэтгэврийн даатгал	33,466,090.42	34,111,776.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,535,372.10	3,904,724.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,819,915.27	3,117,060.14
210204	Ажилгүйдлийн даатгал	686,577.45	777,266.96
210205	Эрүүл мэндийн даатгал	6,860,739.76	7,792,651.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,500,461.50	36,922,148.93
210301	Гэрэл, цахилгаан	3,801,835.05	4,102,230.93
210302	Түлш, халаалт	32,198,836.45	32,014,918.00
210303	Цэвэр, бохир ус	1,499,790.00	805,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,085,896.00	35,189,980.00
210401	Бичиг хэрэг	1,584,400.00	2,374,700.00
210402	Тээвэр, шатахуун	14,153,700.00	23,968,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,676,100.00	1,171,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	883,800.00	2,918,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,687,896.00	4,757,300.00
2105	Нормативт зардал	60,436,195.65	78,209,075.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,300,704.65	68,494,864.45
210502	Хоол, хүнс	5,385,491.00	9,714,211.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,116,115.04	24,591,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,894,215.04	5,982,100.00
210604	Урсгал засвар	7,221,900.00	18,609,000.00
2107	Томилолт, зочны зардал	154,000.00	336,000.00
210702	Дотоод албан томилолт	154,000.00	336,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,295,008.00	1,760,466.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	108,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	37,500.00	132,750.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	485,600.00	769,000.00
210807	Газрын төлбөр	71,408.00	429,716.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,230,598.45	79,949,396.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,915,700.00	3,927,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,314,898.45	76,021,946.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,834,638.50	109,337,672.57
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	62,449,621.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	62,449,621.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,546,800.00	39,000,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,546,800.00	39,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,287,838.50	7,888,051.07
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,287,838.50	7,888,051.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	170,922,899.32	38,288,325.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	170,922,899.32	38,288,325.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	634,572,780.00	864,740,894.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	64,538,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	64,538,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	64,538,300.00
1200042	Бусад орлого	00.00	64,538,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	634,572,780.00	800,202,594.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	2,746,797.50
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,746,797.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	468,171,500.00	751,356,070.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,353,100.00	65,827,826.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	92,353,100.00	65,827,826.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,810,200.00	44,810,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,810,200.00	44,810,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	31,237,980.00	686,817,770.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	31,237,980.00	686,817,770.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	606,306,807.50	774,562,868.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	606,306,807.50	774,562,868.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	557,472,169.00	662,478,398.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,923,161.00	383,481,328.55
210101	Үндсэн цалин	309,589,161.00	288,797,067.87
210102	Нэмэгдэл	12,583,217.00	70,908,566.38
210104	Урамшуулал	28,890,783.00	16,707,694.30
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	1,260,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,368,695.00	53,068,081.02
210201	Тэтгэврийн даатгал	33,466,090.42	36,773,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,535,372.10	4,326,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,819,915.27	3,460,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	686,577.45	865,300.00

210205	Эрүүл мэндийн даатгал	6,860,739.76	7,642,681.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210301	Гэрэл, цахилгаан	3,801,835.05	4,102,230.93
210302	Түлш, халаалт	32,198,836.45	32,014,918.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
210401	Бичиг хэрэг	1,565,800.00	2,585,300.00
210402	Тээвэр, шатахуун	16,752,800.00	22,554,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,676,100.00	1,171,800.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,846,000.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,598,400.00	5,305,800.00
2105	Нормативт зардал		
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,077,843.50	55,950,359.50
210502	Хоол, хүнс	6,417,400.00	8,635,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,505,000.00	7,380,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210604	Урсгал засвар	2,021,900.00	22,829,000.00
2107	Томилолт, зочны зардал		
210702	Дотоод албан томилолт	154,000.00	336,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	108,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	485,600.00	769,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,192,800.00	4,905,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,834,638.50	112,084,470.07
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,546,800.00	39,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,746,797.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	28,265,972.50	90,178,025.93
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	28,265,972.50	90,178,025.93
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	28,265,972.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,265,972.50	118,443,998.43

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	647,540,467.05	70,758,850.16	52,527,726.71	770,827,043.92
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	647,540,467.05	70,758,850.16	52,527,726.71	770,827,043.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	38,288,325.91	38,288,325.91
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	647,540,467.05	70,758,850.16	90,816,052.62	809,115,369.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	719,631,100.00	663,924,841.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	719,631,100.00	663,924,841.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	719,631,100.00	601,475,220.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,624,100.00	383,481,328.55
210101	Үндсэн цалин	382,585,600.00	288,797,067.87
210102	Нэмэгдэл	00.00	70,908,566.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,316,000.00	5,808,000.00
210104	Урамшуулал	36,548,100.00	16,707,694.30
210105	Гэрээт ажлын хөлс	5,174,400.00	1,260,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,077,900.00	53,068,081.02
210201	Тэтгэврийн даатгал	36,773,000.00	36,773,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,326,200.00	4,326,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,460,900.00	3,460,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	865,300.00	865,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,652,500.00	7,642,681.02
2104	Хангамж, бараа материалын зардал	48,244,600.00	36,617,380.00
210401	Бичиг хэрэг	4,272,100.00	2,585,300.00
210402	Тээвэр, шатахуун	29,519,900.00	22,554,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,519,300.00	1,171,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,933,300.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,000,000.00	5,305,800.00
2105	Нормативт зардал	76,181,300.00	56,925,330.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,964,700.00	40,909,330.50
210502	Хоол, хүнс	14,066,600.00	8,635,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,150,000.00	7,380,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,885,000.00	64,944,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,825,000.00	1,315,000.00
210602	Тавилга	29,300,000.00	29,300,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,108,600.00	11,500,000.00
210604	Урсгал засвар	26,651,400.00	22,829,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,850,000.00	336,000.00
210702	Дотоод албан томилолт	1,850,000.00	336,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,091,700.00	1,198,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	475,000.00	108,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,400.00	00.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,500.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	166,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,650,000.00	769,000.00
210807	Газрын төлбөр	169,800.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,676,500.00	4,905,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,676,500.00	4,905,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	62,449,621.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	62,449,621.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	62,449,621.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	719,631,100.00	686,817,770.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	667,321,500.00	686,817,770.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	667,321,500.00	686,817,770.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	52,309,600.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,309,600.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,289,526.50
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		128,908,855.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		128,908,855.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		24,081,029.00
2105	Нормативт зардал		15,041,029.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		15,041,029.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,040,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		9,040,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		104827826.50
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		65,827,826.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		65,827,826.50
2132	Бусад урсгал шилжүүлэг		39,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		39,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		130,366,126.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		130,366,126.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		130,366,126.50

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тариалан сумын Эрүүл мэндийн төв нь иргэн бүрт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй чирэгдэлгүй нээлттэй түргэн шуурхай үзүүлж хүн

амын өвчлөл эндэгдлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44,865.4 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	28,266.0	118,444.00	90,178.0
Авлага	64,538.3	152.1	-64,386.2
Бараа материал	49,827.0	105,991.9	56,164.8
Үндсэн хөрөнгө	628,195.8	591,104.5	-37,091.3
Нийт хөрөнгө	770,827.0	815,692.5	44,865.5
Өр төлбөр	00.00	6,577.12	6,577.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	770,827.1	809,115.4	38,288.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	770,827.0	815,692.5	44,865.4

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 90,178.0 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 64,386.2 төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогыг 2022 онд хүлээн авсантай холбоотой буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 105,991.9 мянган төгрөг болж 56,164.8 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан эм боох материал, хүнсний материал, аж ахуйн материал зарцуулагдаагүй үлдсэн мөн 37,765.2 мянган төгрөгийн эм боох материал хандиваар авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 591,104.5 мянган төгрөг болж 37,091.3 төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд 5,360.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 33,570.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, 76,022.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант онд өр төлбөр 6577.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагад өгөх өртэй холбоотой өр төлбөрийн өсөлтөөс хамаарч байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 809,115.4 мянган төгрөг болж 38,288.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14,114.0 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө худалдан авсан, бараа материал хандиваар авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 146,748.6 мянган төгрөгөөр буюу 22 хувиар өссөн байна. Үүнд цалин хөлс болон урамшуулал, хангамж бараа материал, нормативт зардлуудын өсөлт нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 832,166.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 112,535.0 мянган төгрөгийг бууруулж, 719,631.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй байдлаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 719,631.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 667,321.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 52,309.6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 686,817.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 130,366.1 мянган төгрөгийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 663,924.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 663,924.8 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус эрүүл мэндийн төв нь тайлант онд 130,366.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч бараа үйлчилгээний бусад зардалд 24,081.0 мянга, урсгал шилжүүлэгт 104,827.8 мянга буюу нийт 128,908.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнд ногдох нормативаар	340,918.8	309,073.9	31,844.9	90.6%
2	Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	306,602.7	245,757.7	60,845.0	80.2%

Нэг иргэнд ногдох нормативаар хөтөлбөр арга хэмжээний 31,844.9 мянган төгрөгийн хэлбэлзэл үндсэн болон нэмэгдэл цалин хөлстэй холбоотой үүссэн байна.

Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ хөтөлбөр арга хэмжээний 60,845.0 мянган төгрөгийн хэлбэлзэл нь урамшуулал, тээвэр шатахуун, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, багаж техник хэрэгсэл, урсгал зардал зэргийн хэмнэлттэй холбоотой үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ариун төгс оршихуй Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Баялаг, аудитор С.Эрдэнэчимэг, Ч.Сэлэнгэ, В.Сэлэнгэ нар гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн

аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлэн ажиллаа.

Тариалан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ариун төгс оршихуй аудит ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан үр дүнгийн тайлангийн нийт зардал 511,955.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,119.5 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Төлөвлөлтийн үе шатанд 2022 оны санхүүгийн тайлан бүрэн тайлагнагдаагүй байсан. Гүйцэтгэлийн шатанд энэхүү нөхцөл байдал оршин байхгүй болсон учир дахин шинэчлэн тогтоосон болно. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 802,693.3 мянган төгрөгийн 1.0 хувь буюу 8,026.9 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,421.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 116 мэдээллээс хугацаандаа оруулсан 85, хугацаа хоцроож мэдээлсэн 24, байршуулаагүй 7 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

“АРИУН ТӨГС ОРШИХУЙ АУДИТ”
ХХК-ийн АУДИТОР  /В.СЭЛЭНГЭ/

2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр

